



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР

Наадамчдын зам 1201, Арцатын ам,
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17100
Утас:(976) 7575 7807

Цахим шуудан: Info@ub-procurement.mn
Цахим хуудас: www.ub-procurement.mn

2025.01.28 № 03/215

танай _____-ны № _____-т

Тодруулга оруулах тухай

Тус газраас зарласан НХААГ/20240101683 дугаартай “Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай 27 дугаар орон сууцны барилгыг буулган барилгажуулах төслийн гадна инженерийн сүлжээний ажил (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6 дугаар хороо)”-ыг гүйцэтгэх тендер шалгаруулалтад сонирхогч этгээдээс тодруулга гаргасантай холбогдуулан дараах тодруулгын хариуг хүргүүлж байна.

№	Сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулга	Тодруулгын хариу
1.	ТШЗ 19.2 Тухайн инженер, техникийн ажлын туршлагыг баталгаажуулахын тулд шаардагдсан жилийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн Төрийн үйлчилгээний цахим (ТҮЦ) машинаас авсан цахим тодорхойлолт ирүүлнэ гэж заасан байгаа болно. Энэ хэсэгт шаардсан нийгмийн даатгалын цахим тодорхойлолтыг нь хүргүүлэхдээ Төрийн үйлчилгээний цахим систем буюу E-Mongolia системээс авсан тодорхойлолтоор хүргүүлж болох эсэх, эсвэл зөвхөн Төрийн үйлчилгээний цахим (ТҮЦ) машинаас авсан тодорхойлолтыг хүргүүлэх шаардлагатай талаар тодруулга өгнө үү.	Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 19.2-т “Тухайн инженер, техникийн ажилтнуудын ажлын туршлагыг баталгаажуулахын тулд шаардагдсан жилийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн Төрийн үйлчилгээний цахим (ТҮЦ) машинаас татан авсан цахим тодорхойлолт ирүүлнэ” гэж заагаагүй болно.
2.	ТШЗ 19.3-т заасан БА-3.5 “Цахилгаан дамжуулах шугам сүлжээ, дэд бүтэц, түүний тоног төхөөрөмжийн угсралт”-ын тусгай зөвшөөрлийг шаардсан байгаа билээ. Дээр дурдсан зөвшөөрлийн шаардлагыг Зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5-д заасан Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгох “0.4–35 кВ-ын цахилгаан дамжуулах, шугам, дэд станц, угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил үйлчилгээ эрхлэх” буюу Эрчим хүчний яамнаас олгож буй ТЗ-2.2 “0.4–35 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станц угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөлтэй этгээд нь ТШЗ 19.3-т заасан БА-3.5 бүхий тусгай зөвшөөрлийн шаардлагыг	Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 19.3-т заасан Барилга хот байгуулалтын яамнаас олгодог БА-3.5 Цахилгаан дамжуулах шугам сүлжээ, дэд станц, түүний тоног төхөөрөмжийн угсралтын ажлын төрлийн тусгай зөвшөөрлийн заалтыг Эрчим хүчний яамнаас олгодог ТЗ-2.2 “0.4–35 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станц угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил үйлчилгээ эрхлэх” ажлын төрлийн тусгай зөвшөөрлийн заалт хангана.

хангах боломжтой эсэхийг тодруулж өгнө үү.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт заасны дагуу тодруулгыг цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.